

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САЙНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6	Нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагууд олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН
АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.ДОРЖДЭРЭМ ТАНАА

2019.02.25 № 06/281
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, Технологийн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал Н.Дорждэрэм Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өлзийт экаунт аудит ХХК-ын аудитор Ч.Эрдэнэжав, аудиторын туслах Э.Энхмандах, Ш.Бямбасүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал Технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өлзийт экаунт аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/79 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Тус сургууль нь эрхэм зорилгоо "Монголын дээд боловсролын шинэчлэлийн түүхтэй бөгөөд Азийн бүс нутагт инженер технологийн мэргэжилтний шинэ үеийг бэлтгэх төв байна. Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийг хотхоноор нь хөгжүүлэх зорилго тавин оюутны мэргэжлийн болон хувь хүний хөгжилд онцгой анхаарч тэдэнд шаардлагатай мэдлэгийг эзэмшүүлж, байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж буй орчинд судалж шинжлэх эрмэлзэлтэй, сэтгэн санаачлах, манлайлах чадвартай болгон хөгжүүлэх" гэжээ.

Тус сургууль нь эрдэс баялаг олборлох, боловсруулах аж үйлдвэрийн улсын болон хувийн салбарын хэрэгцээг хангах замаар мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэж, Монгол Улсын дотоодын үйлдвэрлэлийн нэмүү өртгийн түвшинг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах эрхэм зорилготой байна.

Герман Улсын Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) болон Германы Эрдмийн Солилцооны Алба (DAAD) байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль нь дээрх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 95 дугаар тогтоолоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Энэхүү сургуулийг хамтран байгуулж, хөгжүүлэхээр Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын нот бичгээр баталгаажуулсан байна.

Үүнд:

- Германы дээд боловсрол, шинжлэх ухааны тэргүүн туршлагыг удирдлага болгож, Монголын соёл, өвд баттай суурилсан байна
- Сургалт, судалгаа нь бодит хэрэглээнд чиглэсэн, аж үйлдвэрийн түншлэлд түшиглэсэн байх бөгөөд бүтээлч, шүүмжлэлтэй, нээлттэй сэтгэлгээ, манлайллыг хөгжүүлэх.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуулийн захирлын 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А20 тоот тушаалын дагуу одоо мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус сургуулийн дотоод хяналтын нэгж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу ажиллаж тайлант онд эрх үүргийн дагуу нийт 6 зөвлөмж, 1 дүгнэлт бичиж гэм буруутай 3 ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулжээ. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор өмч хамгаалах зөвлөлийн ажиллагаа, гадаадын тусламжаар ирсэн хөрөнгийг үнэлэх, бүртгэх, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, сургалтын төлбөрийн авлага, санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн биелэлтэнд анхаарч ажиллажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт орлогын дүнгээр сонгоход бага байсан тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгосныг гүйцэтгэлийн шатанд хэвээр сонгосон.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,442,040.5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 88,840.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг төлөвлөлтийн үе шатанд тогтоосон 2 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд чанарын холбоотой асуудал үүсээгүй болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- Хувь хүн, иргэнээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа Хувь хүний орлогын албан татварын зохих суутгалыг суутгаагүйг татварын цахим сайтад тайлагнан залруулав.
- Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу үндсэн хөрөнгө, газрын дахин үнэлгээний нэмэгдэл 2,269,178.8 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод бүртгэснийг залруулав.
- Шатах, тослох материалын нярвын тайланг сар болгон бэлтгэн, шатахууны тайлангаа хянаж, хэтрэлт хэмнэлтээ тооцон ажиллаагүйг залруулав.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	12,369.3	
2	Албан шаардлага өгсөн	1	33,122.5	
	Дүн	3	45,491.8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Тайлант онд тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй бөгөөд Бамбай сервис ХХК-аас 33,122.5 мянган төгрөгийн харуул хамгаалалтын гэрээ хийн үйлчилгээ авахдаа харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд худалдан авсан нь “тохиолдсон байх” батламж мэдэгдэл болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дүгээрт “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэх.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй санхүү тайлан бүртгэлийн эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой гадаадын 2 хөтөлбөр, 1 арга хэмжээг нэмж хэрэгжүүлж байгаа бөгөөд 2018 онд 2,317,947.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,264,109.9 мянган төгрөг буюу 97.7 хувиар зарцуулж, үлдэгдэл 93,718.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн шилжүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Энэхүү үүргийн хүрээнд 2018 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын байдлаар нийт 152 ширхэг ил тодын мэдээ байршуулсан ба үүнээс 150 мэдээг хугацаанд нь байршуулжээ. Сар болгон батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн талаар тогтмол мэдээлдэг байна. Харин цаг үетэй холбоотойгоор хагас жилийн санхүүгийн тайлан, төлбөр хураамж зохицуулалтын мэдээлэл зэргийг байршуулжээ.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 асуудалд өгсөн зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. **Үүнд:**

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төрийн банкны 340601336080 тоот жижиг мөнгөн сангийн данснаас 9,969.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн цохолтгүйгээр ажил гүйлгээг бүртгэсэн нь “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй ба Төсвийн байгууллагад мөрдөх кассын ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.3.8-д “Бэлэн мөнгөний машинаас бэлэн мөнгө авах болон карт ашиглан худалдан авалт хийхдээ 1,2-р гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн цохолт, гарын үсэг бүхий зөвшөөрлийг авч анхан шатны баримтанд хавсаргана” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Бэлэн мөнгөний журам зөрчигдөх, кассын хяналт алдагдах.

1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2011 оны 129 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-ыг баримтлан ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагад мөрдөгдөж байгаа Жижиг мөнгөн сангийн журмаа шинэчлэн хяналтаа сайжруулан ажиллана.

2. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 2,400.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь “толилуулга ба тодруулга” болон “хэмжилт” батламж мэдэгдлүүдийг хангаагүй ба Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5–д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Зардлыг ангиллын дагуу бүртгэхгүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврын дагуу зориулалтаар нь зарцуулах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,350,593,875.04</u>	<u>1,459,659,556.78</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	175,000.00	3,057,500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	175,000.00	3,057,500.00
3121	Төгрөг	175,000.00	3,057,500.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	175,000.00	3,057,500.00
33	АВЛАГА	369,256,482.81	452,107,709.83
33300	Татаас, санхүүжилтийн авлага	320,248,282.81	416,340,809.83
335	Бусад авлага	49,008,200.00	35,766,900.00
3351	Байгууллагаас авах авлага	49,008,200.00	35,766,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	981,162,392.23	1,004,494,346.95
351	Түүхий эд материал	874,710,322.94	892,677,846.61
35110	Тусгай зориулалттай материал	840,475,350.54	841,311,032.04
35111	Тусгай зориулалтын материал-Боловсруулалт	26,244,062.40	35,610,174.90
35112	Тусгай зориулалттай материал-Боловсруулалт	2,510,620.00	3,424,899.17
35113	Тусгай зориулалтын материал-Боловсруулалт	934,000.00	4,385,450.50
35130	Эм боох материал	75,450.00	75,450.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,470,840.00	7,870,840.00
354	Хангамжийн материал	106,452,069.29	111,816,500.34
35410	Бичиг хэргийн материал	2,788,634.00	6,154,649.00
35420	Аж ахуйн материал	1,744,500.00	
35430	Сэлбэг хэрэгсэл	3,407,400.00	2,814,300.00
35470	Бусад хангамжийн материал	98,511,535.29	102,847,551.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,622,107,440.88</u>	<u>16,783,928,706.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,622,107,440.88	16,783,928,706.44
392	Биет хөрөнгө	13,601,875,140.94	14,502,951,355.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,982,554,541.00	12,903,895,633.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,026,931,342.80	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	399,310,674.00	399,310,674.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-120,137,568.58	-172,973,147.62
39205	Машин тоног төхөөрөмж	994,712,706.30	1,072,193,465.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-536,960,286.90	-638,519,263.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	639,208,940.87	641,520,040.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-232,806,290.59	-306,495,596.38
39209	Зам, гүүрийн байгууламж		102,687,352.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	318,320,415.00	319,058,415.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-105,434,150.06	-138,635,866.58
39217	Ном	290,037,502.70	320,909,648.67
393	Биет бус хөрөнгө	20,232,299.94	2,280,977,350.78
39301	Програм хангамж	14,908,549.81	16,105,549.81
39302	Хуримтлагдсан элэгдэл		-6,852,949.00
39303	Газар эзэмших эрх	6,245,000.00	6,245,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-921,249.87	-2,170,250.03
39305	Газар эзэмших		2,267,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>14,972,701,315.92</u>	<u>18,243,588,263.22</u>
413	Өглөг	1,097,731.99	00.00

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,097,731.99	
4136	Бусад өглөг	900,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	900,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>14,971,603,583.93</u>	<u>18,243,588,263.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	14,971,603,583.93	18,243,588,263.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	2,904,539,547.50
51101	Өмч: - төрийн		2,904,539,547.50
512	Хуримтлагдсан үр дүн	14,971,603,583.93	13,197,165,853.95
51210	Өмнөх үеийн үр дүн	14,971,603,583.93	14,971,603,583.93
51220	Тайлант үеийн үр дүн		-1,774,437,729.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,141,882,861.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>14,972,701,315.92</u>	<u>18,243,588,263.22</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,703,801,968.70	2,667,602,774.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	763,722,171.40	753,430,765.24
120	Нийтлэг татварын бус орлого	763,722,171.40	753,430,765.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	763,722,171.40	753,430,765.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	525,534,000.00	692,769,549.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,188,171.40	60,661,215.65
122	Тусламжийн орлого	00.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,940,079,797.30	1,914,172,008.77
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,578,909,300.00	1,654,700,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	361,170,497.30	259,471,508.77
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	256,500,000.00	234,820,128.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,670,497.30	6,944,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,707,380.41
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,791,569,909.00	3,038,861,229.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,791,569,909.00	3,038,861,229.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,791,564,721.94	2,945,132,301.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,366,179,359.87	1,524,845,649.95
210101	Үндсэн цалин	1,366,179,359.87	1,524,845,649.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,582,845.09	180,388,796.95
210201	Тэтгэврийн даатгал	95,526,489.01	121,912,120.73
210202	Тэтгэмжийн даатгал	10,894,522.41	15,099,510.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,582,152.26	12,308,005.49
210204	Ажилгүйдлийн даатгал	2,507,243.58	2,824,469.14
210205	Эрүүл мэндийн даатгал	25,072,437.83	28,244,691.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,431,889.85	206,899,691.39
210301	Гэрэл, цахилгаан	38,785,940.63	41,103,975.12
210302	Түлш, халаалт	117,159,253.60	117,334,810.00
210303	Цэвэр, бохир ус	9,548,159.00	13,303,410.00
210304	Байрны түрээс	34,938,536.62	35,157,496.27
2104	Хангамж, бараа материалын зардал	90,225,250.08	59,591,071.61
210401	Бичиг хэрэг	11,498,856.00	14,817,781.60
210402	Тээвэр, шатахуун	15,762,044.46	16,689,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,936,373.14	17,122,956.06
210404	Ном, хэвлэл	5,540,700.00	615,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,312,000.00	2,846,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,175,276.48	7,498,913.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,974,600.00	11,001,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,682,268.00	
210604	Урсгал засвар	14,292,332.00	11,001,450.00

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	8,662,386.00	6,585,957.00
210702	Дотоод албан томилолт	8,662,386.00	6,585,957.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,924,711.21	270,027,518.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,537,075.21	259,472,918.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,767,536.00	4,961,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	620,100.00	592,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	819,583,679.84	685,792,166.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,563,300.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,099,426.36	91,771,292.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	695,920,953.48	594,020,874.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,187.06	93,728,927.79
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,187.06	93,728,927.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		93,728,927.79
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,187.06	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,187.06	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-87,767,940.30	-371,258,455.63
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,403,179,274.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,403,179,274.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-87,767,940.30	-1,774,437,729.98

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,496,832,881.50</u>	<u>2,940,431,141.17</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	548,242,651.20	706,010,849.59
120	Нийтлэг татварын бус орлого	548,242,651.20	706,010,849.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	525,237,300.00	706,010,849.59
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,005,351.20	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,948,590,230.30	2,234,420,291.58
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,578,909,300.00	1,654,700,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,578,909,300.00	1,654,700,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	361,170,497.30	579,719,791.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	256,500,000.00	491,320,128.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,670,497.30	70,692,282.81
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,707,380.41
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,510,433.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,510,433.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,412,826,128.99</u>	<u>2,882,200,886.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,412,826,128.99	2,882,200,886.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,092,572,659.12	2,372,131,149.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,366,051,894.97	1,522,248,303.86
210101	Үндсэн цалин	1,366,051,894.97	1,522,248,303.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,250,132.46	184,083,875.02
210201	Тэтгэврийн даатгал	99,164,321.98	129,208,117.39
210202	Тэтгэмжийн даатгал	11,013,753.58	14,172,540.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,826,327.34	11,553,337.37
210204	Ажилгүйдлийн даатгал	2,084,464.53	4,483,987.45
210205	Эрүүл мэндийн даатгал	23,161,265.03	24,665,892.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,431,889.79	206,899,691.39
210301	Гэрэл, цахилгаан	38,785,940.63	41,103,975.12
210302	Түлш, халаалт	117,159,253.60	117,334,810.00
210303	Цэвэр, бохир ус	9,548,159.00	13,303,410.00
210304	Байрны түрээс	34,938,536.56	35,157,496.27
2104	Хангамж, бараа материалын зардал	54,573,323.60	54,285,955.06
210401	Бичиг хэрэг	8,278,517.00	12,616,979.00
210402	Тээвэр, шатахуун	15,762,044.46	16,569,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,936,373.14	17,122,956.06
210404	Ном, хэвлэл	5,988,250.00	615,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,312,000.00	2,846,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,296,139.00	4,514,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,974,600.00	12,730,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,682,268.00	
210604	Урсгал засвар	14,292,332.00	12,730,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,662,386.00	6,585,957.00

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	8,662,386.00	6,585,957.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,872,850.21	269,311,568.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,485,214.21	258,756,968.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,767,536.00	4,961,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	620,100.00	592,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,755,582.09	115,985,198.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,699,101.20	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,056,480.89	115,985,198.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	320,253,469.87	510,069,737.62
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	320,253,469.87	510,069,737.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	320,253,469.87	510,069,737.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>84,006,752.51</u>	<u>58,230,254.37</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	83,833,095.51	55,347,754.37
2200	Дотоод эх үүсвэрээр	83,833,095.51	55,347,754.37
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	83,833,095.51	55,347,754.37
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	173,657.00	2,882,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,343.00	175,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	175,000.00	3,057,500.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	14,971,603,583.93	14,971,603,583.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00		00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	14,971,603,583.93	14,971,603,583.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00		00.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	14,971,603,583.93	14,971,603,583.93
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	14,971,603,583.93	14,971,603,583.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00		00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	14,971,603,583.93	14,971,603,583.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	2,141,882,861.77	00.00	2,141,882,861.77
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	2,904,539,547.50	00.00	00.00	2,904,539,547.50
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,774,437,729.98	-1,774,437,729.98
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,904,539,547.50	2,141,882,861.77	13,197,165,853.95	18,243,588,263.22

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		175,000.00	(175,000.00)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,317,947,100.00	2,264,109,922.00	53,837,178.00	97.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2,317,947,100.00	2,264,109,922.00	53,837,178.00	97.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,317,947,100.00	2,264,109,922.00	53,837,178.00	97.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,571,294,300.00	1,522,248,303.86	49,045,996.14	96.9
Үндсэн цалин	1,536,294,300.00	1,522,248,303.86	14,045,996.14	99.1
Урамшуулал	35,000,000.00		35,000,000.00	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,555,300.00	184,083,875.02	4,471,424.98	97.6
Тэтгэврийн даатгал	125,703,500.00	129,208,117.39	(3,504,617.39)	102.8
Тэтгэмжийн даатгал	15,712,900.00	14,172,540.04	1,540,359.96	90.2
ҮОМШӨ-ний даатгал	12,570,400.00	11,553,337.37	1,017,062.63	91.9
Ажилгүйдлийн даатгал	3,142,600.00	4,483,987.45	(1,341,387.45)	142.7
Эрүүл мэндийн даатгал	31,425,900.00	24,665,892.77	6,760,007.23	78.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,971,100.00	206,899,691.39	71,408.61	100.0
Гэрэл, цахилгаан	37,215,700.00	41,103,975.12	(3,888,275.12)	110.4
Түлш, халаалт	125,396,300.00	117,334,810.00	8,061,490.00	93.6
Цэвэр, бохир ус	9,199,100.00	13,303,410.00	(4,104,310.00)	144.6
Байрны түрээс	35,160,000.00	35,157,496.27	2,503.73	100.0
Хангамж, бараа материалын зардал	75,571,400.00	75,461,959.29	109,440.71	99.9
Бичиг хэрэг	8,500,000.00	8,576,979.00	(76,979.00)	100.9
Тээвэр, шатахуун	16,060,000.00	16,060,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,280,000.00	17,122,956.06	157,043.94	99.1
Ном хэвлэл	26,369,100.00	26,340,624.23	28,475.77	99.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,407,700.00	2,846,800.00	560,900.00	83.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,954,600.00	4,514,600.00	(560,000.00)	114.2
Эд хогшил, урсгал засварын зардал	9,291,600.00	9,291,600.00	-	100.0
Урсгал засвар	9,291,600.00	9,291,600.00	-	100.0
Томилолт, зочны зардал	6,588,300.00	6,585,957.00	2,343.00	100.0
Дотоод албан томилолт	6,588,300.00	6,585,957.00	2,343.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,627,300.00	124,491,967.00	135,333.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,045,500.00	113,937,367.00	108,133.00	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	4,961,700.00	4,961,700.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	620,100.00	592,900.00	27,200.00	95.6

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	135,047,800.00	135,046,568.44	1,231.56	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	135,047,800.00	135,046,568.44	1,231.56	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,317,947,100.00	2,266,992,422.00	50,954,678.00	97.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,654,700,500.00	1,560,981,572.41	93,718,927.59	94.3
Улсын төсвөөс санхүүжих	1,654,700,500.00	1,560,981,572.41	93,718,927.59	94.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	663,246,600.00	706,010,849.59	(42,764,249.59)	106.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	663,246,600.00	706,010,849.59	(42,764,249.59)	106.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		175,000.00	(175,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,057,500.00	(3,057,500.00)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131.00	121.00	10.00	92.4
АЖИЛЛАГСАДЫН ТОО	65.00	65.00	-	100.0
Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65.00	65.00	-	100.0

4.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		163,368,981.55	-163,368,981.55	
УРСГАЛ ЗАРДАЛ		163,368,981.55	-163,368,981.55	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		163,368,981.55	-163,368,981.55	
Хангамж, бараа материалын зардал		8,548,950.00	-8,548,950.00	
Бичиг хэрэг		4,040,000.00	-4,040,000.00	
Тээвэр, шатахуун		509,000.00	-509,000.00	
Ном, хэвлэл		3,999,950.00	-3,999,950.00	
Эд хогшил худалдан авах		3,439,000.00	-3,439,000.00	
Урсгал засвар		3,439,000.00	-3,439,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		145,162,601.14	-145,162,601.14	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		145,162,601.14	-145,162,601.14	
Бараа үйлчилгээний бусад зардал		6,218,430.41	-6,218,430.41	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,218,430.41	-6,218,430.41	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		0.00	0.00	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		0.00	0.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		0.00	0.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭХ		163,368,981.55	-163,368,981.55	
Нэмэлт санхүүжилтийн орлого		163,368,981.55	-163,368,981.55	
Төрийн болон орон нутгин өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		75,085,454.53	-75,085,454.53	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		70,576,146.61	-70,576,146.61	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,707,380.41	-17,707,380.41	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131.00	121.00	10.00	92.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСДЫН ТОО	65.00	65.00	-	100.0
Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/				
ЭМЧЛҮҮЛЭЛГСДИЙН ТОО				
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65.00	65.00	-	100.0

5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо: 2019 он	Аудитын н нэр: Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2019/383/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан босго үнийг баримтлан Харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулаагүй.	33,122.5	Албан шаардлага өгөх	Захирал	Н.Дорждэрэм
2	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн.	2,400.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Э.Ууганцэцэг
3	Сангийн сайдын 2011 оны 129 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-ын 3.3.8 дугаар заалтыг баримтлан ажиллаагүй.	9,969.3	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Э.Ууганцэцэг
	Дүн	45,491.8			

